

ТЭРГҮҮНИЙ ЗААХ АРГА ЗҮЙЧ БАГ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Тус нэгтгэлийн офицер, ахлагч нарын цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдан зохион байгуулан явуулах, заах арга зүй, хүнтэй ажиллах ур чадварыг дээшлүүлэх, сургалтын цахим хэлбэр, технологийг нэвтрүүлэх, шинэ бүтээл, оновчтой

санал, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Тэргүүний заах арга зүйч баг" шалгаруулах уралдааныг зохион байгуулж явууллаа. Тэмцээнд баг тус бүр багийн ахлагч, сургагч, техникийн ажилтан гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон бөгөөд цахим сургалтын шинэлэг арга хэлбэрийг

ашиглан оролцсон нь онцлог байлаа. Тэмцээний тэргүүн байрт ахлах дэслэгч Б.Золбаяр ахлагчтай танкийн батальоны баг тэргүүн байрт шалгарсан бол хошууч Э.Энхбаяр ахлагчтай артиллерийн холимог дивизионы баг хоёрдугаар байрт шалгарсан юм.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



ТЭР БОЛ ЦЭРГИЙН ДАРГА...



Энэ зурган дээрх хүн бол Агаарын десантын XVIII корпусын АНУ-ын Армийн 82-р дивизийн командлагч, хошууч генерал Крис Донахуй юм. Тэрээр Афганистаны Кабул хотын Хамид Карзай олон улсын нисэх онгоцны буудлаас Афганистаныг орхин гарсан Америкийн цэргийн хамгийн сүүлийн

уудирдагч юм. Цэргийн дарга хүний ёсоор бүх цэрэг гаргасны дараа хамгийн сүүлийн нислэгээр буцаж Афганистан дахь улсад 20 жил үргэлжилсэн америкийн цэргийн ажиллагаа дуусгавар болж байгаа нь энэ юм. Сонирхуулахад Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад

явагдсан олон үндэстний цэргийн ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бие бүрэлдэхүүн 2003 оноос эхлэн үүрэг гүйцэтгэсэн ба энэ ажиллагаа 2021 онд дуусгавар болсон юм.

Уг ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс давхардсан тоогоор 7100 орчим цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн бөгөөд сүүлчийн ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн энэ оны тав болон зургаадугаар сард эх орондоо ирсэн юм. Афганистан улсад Монголын Зэвсэгт хүчний цэргийн багууд үүрэг гүйцэтгэсэнээр даян дэлхийн энх амгалангийн үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулсны зэрэгцээ монгол эх орон, монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөж, мэргэжлийн ур чадвар, сахилга бат, зохион байгуулалтаараа олон үндэстний цэргийн алба хаагчдад үлгэр дуурайл болсоор ирснийг гадаад орнуудын төр, засгийн удирдлага, цэргийн мэргэжилтнүүд өндрөөр үнэлсэн билээ.

ОН ГАРСААР 6200 ОРЧИМ ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭЭД БАЙНА



Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд чирэгдэлгүй болгох зорилгын хүрээнд Батлан хамгаалахын төв архив нь иргэд, албан байгууллагаас хүсэлт хүлээн авах, мэдээлэл, лавлагаа өгөх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн нь иргэдийн талархлыг хүлээж байна. Цахим хаягнаас та цэргийн албатай холбоотой бүх төрлийн лавлагаа мэдээлэл, төлбөр хураамж, хаяг, байршил зэрэг бүх мэдээлэл, үйлчилгээг авах боломжтой юм.

Тухайлбал, Батлан хамгаалахын Төв архиваас иргэдийн эрэлт хүсэлтийг хүлээн авах, хариу лавлагаа, мэдээллээр үйлчлэх ажлыг тасралтгүй шуурхай явуулахын тулд иргэдийн хүсэлтийг байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан авч байна. Ингэхдээ цахим захиалгын хамгийн хялбар шийдэл болох "Чатбот" үйлчилгээг нэвтрүүлжээ. Мөн вэб хуудсандаа лавлагааны

төрлөөр захиалгын маягт болон өргөдөл, гомдол, санал хүсэлтийн цэсийг байршуулсан. Ингэснээр иргэд архивын үйлчилгээг түргэн шуурхай хүртэх боломж бүрдэж байгаа юм. Мөн Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа архив, албан хэрэг хөтлөлтийн програмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаа байгууллагуудыг судалсны үндсэн дээр "Edoc", "Архив албан хэрэг хөтлөлтийн цогц систем" гэсэн хоёр программ хамгийн үр дүнтэй, хямд өртөгтэйг олж мэдсэн юм.

Цаашид уг програмуудыг Батлан хамгаалах салбарын харьяа нэгж, байгууллагууд, ангиуд болон аймаг, нийслэлийн Цэргийн штабын архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлж цахимжуулбал архивын өдөр тутмын үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах бололцоог бий болгох шинэ шийдэл нь болно гэж үзэж байна. Ингэснээр Засгийн

газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй үзүүлэх" гэсэн үндсэн зорилгыг хангах гол ажил болох юм. Түүнчлэн цахим үйлчилгээний нэгдсэн портал "E-Mongolia"-д холбогдох боломжийг бий болгож байгаагаараа онцлог ажээ. Үүний дагуу бид Батлан хамгаалах салбарын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд шинэ программыг нэвтрүүлж хэрэгжүүлэх талаар БХЯ-нд "Цахим архив, албан хэрэг хөтлөлт" хөтөлбөрийг албан бичгээр хүргүүлээд байгаа талаар тус архивын алба хаагчид мэдээллээ.

Т а ш р а м д сонирхуулахад Батлан хамгаалахын төв архив нь цахим үйлчилгээг нэвтрүүлснээр 2020 онд 8000 орчим иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн бол 2021 оны 08 дугаар сарын байдлаар 6200 орчим иргэдэд үйлчлээд байна.

ЭНЭ САРЫН 2-4-НД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

Элсэлтийн ерөнхий шалгалт - 2021 - ий г наймдугаар сарын 19-22-нд орон даяар зохион байгуулсан.

Гэвч коронавируст халдварын улмаас дээрх хугацаанд шалгалтад оролцож чадаагүй 170 бүртгүүлэгч байгаагаас

БШУЯ-наас мэдээлсэн юм. Иймд тухай хүүхдүүдээс есдүгээр сарын 2-4-нд шалгалт авахаар товлосон.

Шалгалт өгөхөөр очихдоо дээрх хүүхдүүд иргэний үнэмлэх, бүртгэлийн хуудас, суудлын хуваарь, бүрэн дунд боловсролын үнэмлэх болон

Эмнэлгийн магадалгаа буюу коронавируст халдварын улмаас шалгалтад оролцож чадаагүйг нотлох эрүүл мэндийн байгууллагаас гаргасан бичгийг авч очих шаардлагатай юм.

Бүртгүүлэгчдэд зориулан бэлтгэсэн багц мэдээллийг хүргэж байна.

ЭЭШ-ЫН БАТЛАМЖ ХУУДСАА ХААНААС АВАХ ВЭ?

9-р сарын 02-04-ний өдрүүдэд шалгалт өгсөн шалгуулагчдын батламж хуудсыг **9-Р САРЫН 5-наас** эхлэн тараана. Орон нутагт шалгалт өгсөн шалгуулагчид тухайн аймгийнхаа **БОЛОВСРОЛЫН ГАЗРААС** авна. Нийслэлд шалгалт өгсөн шалгуулагчид **БҮТ**-өөс авна.

ДҮН ОНООГОО ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

Шалгуулагчдын дүн оноог шалгалт өгснөөс хойш 24 цагийн дотор WWW.EEC.MN цахим хуудасны **"ШАЛГУУЛАГЧИЙН БУЛАН"**-д байршуула. Иймд шалгуулагч өөрийн бүртгэлийн дугаар нууц үгээ ашиглан шалгуулагчийн булангаар нэвтэрч **ДҮН ОНООГОО** харна.

ШАЛГАЛТЫН ТӨВИЙН БАЙРШИЛ ХААНА ВЭ?

ТУХАЙН АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ
Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Орхон, Төв, Увс, Ховд, Хөвсгөл

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАЛГУУЛАГЧИД
Дархан-Уул аймаг дахь ЦЗУТИС

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ШАЛГУУЛАГЧИД
Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын 5-р сургууль

УЛААНБААТАР ХОТЫН ШАЛГУУЛАГЧИД
МУБИС-ын А байр /Багийн дэргийн автобусны буудлын хойд талд/

ШАЛГАЛТАД ЯМАР БИЧИГ БАРИМТТАЙ ОЧИХ ВЭ?

1. Иргэний үнэмлэх
2. Бүртгэлийн хуудас
3. Суудлын хуваарь
4. Бүрэн дунд боловсролын үнэмлэх
5. ЭМНЭЛГИЙН МАГАДАЛГАА /Коронавируст халдварын улмаас шалгалтад оролцож чадаагүйг нотлох эрүүл мэндийн байгууллагаас гаргасан бичиг баримт/